



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/185

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам"-ын 2.17 дах заалт, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Бүгд Найрамдах Солонгос Улсын Асан анагаахын төв хооронд 2011 оны 7 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох 2 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.

2. Зөвшөөрлийн гэрчилгээг баталгаажуулж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.


САЙД



Д.САРАНГЭРЭЛ

080758

Эрүүл мэндийн сайдын
2019 оны 04 сарын 18-ны өдрийн
дугаар тушаалын хавсралт



МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харъяалал	Монгол Улсад ажиллах байгууллага	Хамтран ажиллах гадаадын байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Мүн Дог Буг Moon Deok Bok	Бүгд Найрамдах Солонгос Улс	Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг	Бүгд Найрамдах Солонгос Улсын Асан Анагаахын төв	ГЭ0002226	Мэс засал судлал	Эмчлэх	2019.04.25-2019.04.28 /4 хоног/
2.	Жон Дун Хван Jung Donghwan	Бүгд Найрамдах Солонгос Улс	Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг	Бүгд Найрамдах Солонгос Улсын Асан Анагаахын төв	ГЭ0002227	Мэс засал судлал	Эмчлэх	2019.04.25-2019.04.28 /4 хоног/